



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 10 өдөр

Дугаар СХШ-2025/27

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн Ерөөгийн бүсийн сум
дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн хяналт шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 7 дүгээр сарын 30-ны өдрийн СХШ-2025/04/ТШЗ дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангийн санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулан зөвлөх зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын СХШУАБ Т.Мөнхзул ахлан, дотоод аудитор Д.Ванчигмаа 2025 оны 08 дүгээр сарын 04-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтаар Ерөө бүсийн сум дунд ойн ангийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангийн нь улсын бүртгэлийн 3746283 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100130213008 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100130213401 дугаартай данснудыг ашиглаж байна.

1.5 Тус газрын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Ерөөгийн бүсийн сум дундын ойн ангийн дарга Г.Энхбат, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Өлзиймаа нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6 Ерөө бүсийн дундын ойн анги нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны 02 сарын 15 өдрийн А/66 тоот захирамж 8 хүний орон тоо батлагдсанаас одоогийн байдлаар байгууллага нь дарга 1, ахлах инженер 1, техникч-1, нярав 1 нягтлан бодогч 1, гэсэн 5 оронтой ажилласан байна.

4325001177

1.7 Ерөө бүсийн сум дундын ойн анги нь нь Монгол Улсын Ойн тухай хуулийн дагуу ойн нөөц, баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг гэрээгээр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, ойн аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажиллагааны чиглэлээр байгуулагдсан байна .

Ерөө бүсийн сум дундын ойн анги нь нийт 677531га газартай бүсээр ангилбал хамгаалалтын бүсийн хязгаарлалтын бүс 355113 га ,ногоон бүс 27730га , хориотой зурвасын ойн 44854га ,ашиглалтын бүсийн ойн 249834 га газрууд хамаарагдаж байна.Ойн анги нь 21ойн нөхөрлөл ,38 аж ахуйн нэгж байгууллагуудтай ойн санг гэрээгээр эзэмшүүлж ойжуулалт,нөхөн сэргээлт,мод үржүүлэг, талбай тусгаарлах ойн ашиглалтыг , ойн менежмент төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн ажиллаж байна.

Ерөө сумын Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх тухай Засаг даргын 2024 оны А/155,А/309 дугаартай захирамжийг хэрэгжүүлэхтэй холбоотой сумын хэмжээнд Улсын ойн үрийн нөөцийн сангаас олгосон Эгэл нарсны 2-р зэргийн үр 0,5кг Моносны 1-р зэргийн үр 2кг ,далан хальсны 2-р зэргийн үр 0,2кг-ийг өөрийн ойн ангийн мод үржүүлгийн газартаа стандартын дагуу тарьж ургуулан ажилласан байна

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Ерөө бүсийн сум дундын ангийн ойн ангийн нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт”-ыг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

Төсвийн төлөвлөлт

Ерөө бүсийн дундын ойн анги 2024 онд орон нутгийн төсвөөс 58,928.2 мянган төгрөгөөр ,төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 123,058.0 мянган төгрөгөөр нийт 181,986.0 мянган төгрөгөөр төсөв батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

2024 оны Төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

/ Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	181,986.2	158,076.7	23,909.5	87.0

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,124.8	134,328.4	18,796.4	88.0
210101	Үндсэн цалин	98,636.4	77,022.5	21,613.9	78.0
210102	Нэмэгдэл	54,488.4	53,335.3	1,153.1	98.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,970.5	(3,970.5)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,020.5	16,635.3	2,385.2	87.0
210201	Тэтгэврийн даатгал	13,375.6	11,390.2	1,985.4	85.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,411.2	1,282.9	128.3	91.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	705.6	641.4	64.2	91.0
210204	Ажилгүйдлийн даатгал	705.6	639.3	66.3	91.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,822.5	2,681.5	141.0	95.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,300.0	1,000.0	300.0	77.0
210301	Гэрэл, цахилгаан	300.0	-	300.0	-
210304	Байрны түрээс	1,000.0	1,000.0	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	4,622.9	4,600.0	22.9	95.0
210401	Бичиг хэрэг	500.0	500.0	-	-
210402	Тээвэр, шатахуун	3,500.0	3,500.0	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300.0	300.0	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	322.9	300.0	22.9	93.0
2107	Томилолт, зочны зардал	770.0	-	770.0	-
210702	Дотоод албан томилолт	770.0	-	770.0	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,698.0	1,513.0	1,185.0	56.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50.0	-	50.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	120.0	-	120.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170.0	163.0	7.0	96.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88.0	-	88.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.0	450.0	-	-
210807	Газрын төлбөр	1,820.0	899.9	920.0	49.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	450.0	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	450.0	-	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	450.0	450.0	-	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	181,986.2	158,076.7	23,909.5	87.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	181,986.2	158,076.7	23,909.5	87.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	123,058.0	158,076.7	23,909.5	87
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123,058.0	158,076.7	23,909.5	87
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13.0	13.0	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	-
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.0	6.0	-	-
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	-

620002	Гүйцэтгэх ажилтан	2.0	2.0	-	
620003	Үйлчлэх ажилтан	3.0	3.0	-	

Төсвийн төлөвлөлт

Ерөө бүсийн дундын ойн ангийн 2025 оны эхний хагас жилд орон нутгийн төсвөөс 69,122.2 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 45,000.0 мянган төгрөгөөр нийт 114,122.2 мянган төгрөгөөр төсөв батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

2025 оны эхний хагас жилээр, орон нутгийн төсвөөс 63,936.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 42,157.5 мянган төгрөг нийт 106,093.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны урсгал зардалд 103,077.3 мянган төгрөгийг зарцуулсан, санхүүжилтийн харилцах дансанд 3,015.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,044.8 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 5,029.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 790.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 900.0 мянган төгрөгөөр хангамжийн бараа материалын зардлаас 650.0 мянган төгрөгөөр, томилолын зардлыг 400.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 2,175.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр тайлангийн 2.хүснэгтээр харуулав.

2025 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2

/ Мянган төгрөг /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	114,122.2	103,077.4	11,044.8	90.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,419.6	89,390.0	5,029.6	94.7
210101	Үндсэн цалин	47,617.2	49,255.9	(1,638.7)	103.4
210102	Нэмэгдэл	40,776.0	33,856.0	6,920.0	83.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,326.4	2,040.5	1,285.9	61.3
210104	Урамшуулал	2,700.0	4,237.6	(1,537.6)	156.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,802.6	11,012.4	790.2	93.3
210201	Тэтгэврийн даатгал	8,025.6	7,541.4	484.2	94.0
210202	Тэтгэмжийн даатгал	944.4	848.3	96.1	89.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	472.2	424.1	48.1	89.8
210204	Ажилгүйдлийн даатгал	472.2	424.1	48.1	89.8
210205	Эрүүл мэндийн даатгал	1,888.2	1,774.4	113.8	94.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	900.0	-	900.0	-
210304	Байрны түрээс	900.0	-	900.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,100.0	2,450.0	650.0	79.0
210401	Бичиг хэрэг	200.0	200.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,100.0	2,100.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150.0	150.0	-	100.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650.0	-	650.0	-
2105	Нормативт зардал	100.0	-	100.0	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100.0	-	100.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500.0	-	500.0	-
210604	Урсгал засвар	500.0	-	500.0	-
2107	Томилолт, зочны зардал	400.0	-	400.0	-
210702	Дотоод албан томилолт	400.0	-	400.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,300.0	125.0	2,175.0	5.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	600.0	125.0	475.0	20.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180.0	-	180.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70.0	-	70.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.0	-	450.0	-
210807	Газрын төлбөр	1,000.0	-	1,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	400.0	100.0	300.0	25.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400.0	100.0	300.0	25.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200.0	-	200.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200.0	-	200.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200.0	-	200.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	114,122.2	106,093.6	8,028.6	93.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	114,122.2	106,093.6	8,028.6	93.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,122.2	63,936.1	5,186.1	92.5
320001	Орон нутгийн төсвөөс	69,122.2	63,936.1	5,186.1	92.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	45,000.0	42,157.5	2,842.5	93.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.0	42,157.5	2,842.5	93.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,016.2	(3,016.2)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.0	5.0	1.0	83.3
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1.0	1.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.0	4.0	-	100.0

2.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд:

2024 онд тус дансанд үндсэн үйл ажиллагаанаас 27,077.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж холбогдох зардалд зарцуулсан байна. 2,404.0 мянган төгрөгийн хангамжийн материал, албан томилолт 5,760.0 мянган төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардал 18,913.1 мянган төгрөгийг зарцуулсан, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 15,138.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. хангамжийн материал 1,000.0 мянган төгрөгийн зарцуулж 14,138.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна .

2.4. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

Хүснэгт 3

дд	Үзүүлэлт	2024		хэтрэл, хэмнэлт	Хувь	2025 эхний хагас жилийн байдлаар		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Төлөөлөгөө	Гүйцэтгэл			Төлөөлөгөө	Гүйцэтгэл		
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,124.8	134,327.8	18,796.5	88	94,419.6	89,390.0	5,029.6	85
2	Үндсэн цалин	98,636.4	77,022.5	21,613.9	78	47,617.2	49,255.9	1,638.7	97
3	Нэмэгдэл	54,488.4	53,335.3	1,153.0	98	6,026.4	33,856.0	6,920.0	83
4	Урамшуулал		3,970.0	3,970.0			6,278.1	2,823.5	64
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,020.5	16,636.3	2,385.2	88	11,802.6	11,012.3	790.3	83

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 2024 онд 18,796.5 мянган төгрөгөөр 2025 оны эхний хагас жилийн байдлаар 17,268.0 мөнгөн төгрөгөөр тус тус хэмнэсэн нь батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой байна.

2.5 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

2024-2025 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг хүртэл хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авалт хийдээгүй байна

2.6 Авлага, өр төлбөрийг баталгаажуулж, данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх

Ойн анги 2024 онд 6 аж ахуйн нэгж байгууллагуудыг ойгоос мод бэлтгэх, талбай тусгаарлах ойн ашигласны төлбөрийн тооцоог 27,704.9 мянган төгрөгийн төлөлт хийдээгүй байхад эрхийн бичгийг олгосон бөгөөд нягтлан бодох бүртгэлийн авлагын дансанд бүртгэлд тусаагүй авлага өглөгийн тооцоо нийлж баталгаажуулалт хийгээгүй хүснэгт дээр харуулсан.

Хүснэгт 4

№	ААНБ-ын нэр	Сумын ИТХ-аар бэлтгэх модны хэмжээ /м3/		Бэлтгэсэн модны хэмжээ /м3/		Сумын ойн нөөц ашигласны /төгрөг/	ААНБ ойн нөөц ашигласны төлбөрийн гүйцэтгэсэн /төгрөгөөр/	Үлдэгдэл /төгрөг/
		Хөрөглөө	Түлээ	Хөрөглөө	Түлээ			
1	Буян-Од	2090	464	2090	464	42,885.7	35,094.4	7,791.3
2	Бугант нандин	1822	503	1822	503	51,864.3	43,839.3	8,025.0

3	Ерөө ой мод	810	228	810	228	16,129.1	12,848.0	3,281.1
4	Сэлэнгэ бугант	1941	530	1941	530	50,427.9	47,215.0	3,212.9
5	Бугант гол	1077	316	1077	316	24,149.7	21,689.0	2,460.7
6	Бугант Чулуут овоо	562	209	562	209	9,316.7	6,382.1	2,934.6
Дүн		8302	2250	8302	2250	194,773.4	167,067.8	27,705.6

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг байна.

1. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн. Санхүүгийн тайлангийн аудит дүгнэлтэд Ерөө бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөмж, зөрчил талаар дурдаагүй байна

2.6 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Үндсэн хөрөнгө:

2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл/анхны өртгөөр/ 317,508.3 мянган төгрөг болж 149,569.3 мянган төгрөгөөр өссөн

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 124,795.8 мянган төгрөг бөгөөд 192,712. мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

Монгол германы хамтарсан "Stream,, төслөөс 16,443.2 мянган төгрөгийн өртөгтэй ширээ сандал шкаф зэргийн үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн байна.

Монгол Солонгосын хамтарсан Ногоон хэрэм төслөөс 133,126.0 мянган төгрөгийн өртөгтэй иж бүрэн тусгай зориулалтын галыг манангаар унтраах Hyundai Porter-II маркийн авто машиныг үнэ төлбөргүй хүлээлгэн өгснийг үндсэн хөрөнгийн дансны бүртгэлд орлогот авсан

Үндсэн хөрөнгийн бүртгэлд тээврийн хэрэгсэл Land cruiser марк машин 30,000.0 мянган төгрөгөөр, УАЗ фургон авто марк машин 26,000.0 мянган төгрөгөөр анхны өртгөө бүрэн нөхсөн дахин ашиглах боломжгүй хөрөнгө бүртгэлтэй байна тайлант элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн тээврийн хэрэгсэл нэр дахин ашиглах боломжгүй 56,080.0 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хандаагүй.

Байгууллагын тооллогын комисс нь хагас жил бүтэн жилээр ажиллахдаа хөрөнгө нэг бүрчлэн нүд үзэж, үнэн зөв чанартай тоолох шаардлагатай байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан удирдлагаар батлуулж, хэрэгжүүлж ажиллаагүй байна

2.7 Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг заавар аргачлалын дагуу бүрэн үнэн зөв хөтөлсөн эсэх

Худалдан авалт нь цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй, нэхэмжлэхийн баримтад бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсаргасан 2024 онд 5,144.0 мянган төгрөгийн худалдан авалтыг бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь ".Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь " Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг зөрчсөн байна

2024 онд 6 иргэнтэй үрийн байнгын талбай тусгаарлалтын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлсэн хөлсийг олгохдоо хүний орлогын албан татварт 300.000.0 (Гурван зуун мянган төгрөг)-ийг суутган

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно.", 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.8Төсөвт төвлөрүүлэх орлогын үндэслэлтэй төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн байдал

2024 онд 33 аж ахуйн нэгж болон 12 нөхөрлөлтэй мод бэлтгэх гэрээ байгуулсан байна. Тайлант жилийн хугацаанд нийт 1423 ширхэг мод бэлтгэх эрхийн бичгийг олгож, ойн нөөц ашигласан төлбөрийн орлогоос төрийн санд 573,450.6

мянган төгрөгийг төвлөрүүлж гүйцэтгэл 80 хувьтай буюу 130,917.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар 30 аж ахуйн нэгж болон 2 нөхөрлөлтэй мод бэлтгэх гэрээ байгуулж нийт 528 ширхэг мод бэлтгэх эрхийн бичгийг олгож ойн нөөц ашиглалтын төлбөрийн орлогод 926,953.2 мянган төгрөгийг бүрдүүлж төрийн санд төвлөрүүлж гүйцэтгэл 82 хувьтай гарсан байна.

2.9 Аймгийн ИТХ-аар баталсан 2024-2025 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоолын хэрэгжилт

Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 01-р дугаар сарын 09-ний өдрийн 123 дугаар тогтоолоор Ерөө суманд мод бэлтгэх хуваарийг 16842 м³ хэрэглээ, 10883 м³ түлээ нийт 27725 м³ бэлтгэх хуваарь 209,3 га талбайд ойжуулалт, Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 02-р дугаар сарын 26-ний өдрийн 124 дугаар тогтоолоор Ерөө суманд мод бэлтгэх хуваарийг 11685 м³ хэрэглээ, 2462 м³ түлээ нийт 14147 м³ бэлтгэх хуваарь 210,1 га талбайд ойжуулалт хийхээр баталсан. Мод бэлтгэлийн талбайн тусгаарлалтыг 33 аж ахуйн нэгж болон 9 нөхөрлөлд 148 талбарт нийт 1610,5 га газар хэрэглээ болон түлээний зориулалттай мод бэлтгэх талбайн тусгаарлалт хийж, эхлэлийн акт болон технологийн картыг бүрдүүлэн ажилласан. 2024 онд эдгээр эрхийн бичигт үндэслэн нийт 35745,1 м³ мод, модон материалыг (үүнээс 34371,4 м³ хэрэглээний, 1767,0 м³ түлээний) 1347 ширхэг гарал үүслийн гэрчилгээгээр баталгаажуулан олгосон.

№	ААНБ-ын нэр	Сумын ИТХ-аар бэлтгэх модны хэмжээ /м ³ /		Бэлтгэсэн модны хэмжээ /м ³ /		Үлдэгдэл модны хэмжээ /м ³ /		Хэрэгжилт хувь	
		Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ
1	Алтан Солин	465	203	250	157	215	46	53.8	77.3
2	Буян-Од	2090	464	1560	363	530	101	74.6	78.2
3	Бугант нандин	1822	503	1375	331	447	172	75.5	65.8
4	Бугант говь	1090	306	1090	306	0	0	100	100
5	Ерөө ой мод	810	228	570	108	240	120	70.4	47.4
6	Номин од	1850	519	1300	387	550	132	70.3	74.6
7	Сэлэнгэ бугант	1941	530	1741	448	200	82	89.7	84.5
8	Сосна	1325	379	1285	379	40	0	97.0	100
9	Бугант гол	1077	316	950	279	127	37	88.2	88.3
10	Үзэсгэлэнт бугант	520	160	520	160	0	0	100	100
11	Бугант минж	637	163	570	156	67	7	89.5	95.7
12	ЭБНЗ	840	240	840	240	0	0	100	100
13	Шаамарзалаа толгой	310	132	310	132	0	0	100	100
14	Тэба гацуур	80	13	80	13	0	0	100	100

15	Бугант Чулуут овоо	562	209	315	134	247	75	56.0	64.1
16	Түмэнсарлагтан	290	129	290	129	0	0	100	100
17	УБТЗ-ын МБУ	1683	366	1683	366	0	0	100	100
18	Бугант номин	985	306	985	306	0	0	100	100
19	Баянсуудал шүтээн	1013	311	1013	311	0	0	100	100
20	Жаврай	1075	305	1030	304	45	1	95.8	99.7
21	Номголжин	614	220	614	220	0	0	100	100
22	Нугын хишиг	795	164	795	164	0	0	100	100
23	Өгөөж хараа	725	254	725	254	0	0	100	100
24	Түмэндалай	1024	283	1024	283	0	0	100	100
25	Цогт Манлай	1041	277	1041	277	0	0	100	100
26	Иэн бирс	310	180	150	107	160	73	48.4	59.4
27	Цант ажнай	40	7	40	7	0	0	100	100
28	Ар санжинт	572	110	472	83	100	27	82.5	75.5
29	Ерөөлт хангай	326	53	100	15	226	38	30.7	28.3
30	Мандал оргил	151	107	151	107	0	0	100	100
31	Эгэл нарс	330	65	330	65	0	0	100	100
32	Эн би констракшн	203	67	103	50	100	17	50.7	74.6
33	Сансар хараа	480	165	330	133	150	32	68.8	80.6
34	Хангайн Бугант ОН	100	100	100	100	0	0	100	100
35	Хөвчийн ой ОН	100	100	100	100	0	0	100	100
36	Баялаг ОН	100	110	100	110	0	0	100	100
37	Бугант баянгол ОН	60	60	60	60	0	0	100	100
38	Бугант баянжин ОН	50	50	50	50	0	0	100	100
39	Гурван гол ОН	100	100	100	100	0	0	100	100
40	Зулзган төгөл ОН	100	100	100	100	0	0	100	100
41	Их хөвч	100	100	100	100	0	0	100	100
42	Шаазгайт ОН	100	100	100	100	0	0	100	100
43	Элбэг ОН	100	100			100	100	0	0
44	Эгүд ОН	100	100	100	100	0	0	100	100
45	Бэх бөх	100	0	100		0	0	100	
46	Иргэд	318	4508		4508	318	0	0	100
Дүн		28504	13262	24642	12202	3862	1060	86.5	92.0

Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 12-р сарын 30-ний өдрийн 23 дугаар тогтоолоор Ерөө суманд мод бэлтгэх хуваарийг 2826 м3 түлээ бэлтгэх, Ерөө сумын ИТХ-ын 2025 оны 01-р сарын 31-ний өдрийн 30 дугаар тогтоолоор Ерөө суманд мод бэлтгэх хуваарийг 32405 м3 хэрэглээ, 4384 м3 түлээ нийт 36789 м3 бэлтгэх хуваарь 441,5 га талбайд ойжуулалт, Ерөө сумын ИТХ-ын 2025 оны 06-р сарын 20-ний өдрийн 42 дугаар тогтоолоор Ерөө суманд мод бэлтгэх хуваарийг 2503 м3 хэрэглээ, 342 м3 түлээ нийт 2845 м3 бэлтгэх хуваарь 27,16 га талбайд ойжуулалт хийхээр

баталсан. Мод бэлтгэлийн талбайн тусгаарлалтыг 32 аж ахуйн нэгж болон 6 нөхөрлөлд 78 талбарт нийт 908 га газар хэрэглээ болон түлээний зориулалттай мод бэлтгэх талбайн тусгаарлалт хийж, эхлэлийн акт болон технологийн картыг бүрдүүлэн ажилласан. 30 аж ахуйн нэгж болон 2 нөхөрлөлтэй мод бэлтгэх гэрээ байгуулан хамтран ажилласан. Мод бэлтгэх эрхийн бичгийг 528 ширхэг үнэт цаасаар олгож, үүний үр дүнд 1026953,2 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн. 2025 онд эдгээр эрхийн бичигт үндэслэн нийт 17555,5 м³ мод, модон материалыг (үүнээс 16086,8 м³ хэрэглээний, 714 м³ түлээний) 1139 ширхэг гарал үүслийн гэрчилгээгээр баталгаажуулан олгосон.

№	ААНБ-ын нэр	Сумын ИТХ-аар бэлтгэх модны хэмжээ /м3/		Бэлтгэсэн модны хэмжээ /м3/		Үлдэгдэл модны хэмжээ /м3/		Хэрэглээ	Түлээ
		Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ	Хэрэглээ	Түлээ		
1	Алтан Солин	785	75	142	12	643	63	18.1	16.0
2	Буян-Од	2092	287	1332	182	760	105	63.7	63.4
3	Бугант нандин	1293	217	980	173	313	44	75.8	79.7
4	Бугант говь	1010	116	680	54	330	62	67.3	46.6
5	Ерөө ой мод	1031	139	249	40	782	99	24.2	28.8
6	Номин од	2590	342	1500	241	1090	101	57.9	70.5
7	Сэлэнгэ бугант	2777	419	2043	262	734	157	73.6	62.5
8	Сосна	2650	405	1405	242	1245	163	53.0	59.8
9	Бугант гол	898	132	505	62	393	70	56.2	47.0
10	ЭБНЗ	901	112	700	88	201	24	77.7	78.6
11	Үзэсгэлэнт бугант	292	29	80	4	212	25	27.4	13.8
12	Бугант минж	1330	143	801	162	529	-19	60.2	113.3
13	Шаамарзалаа толгой	435	38	435	38	0	0	100.0	100.0
14	Бугант Чулуут овоо	520	63	305	40	215	23	58.7	63.5
15	Бугант ногоон сибирь	838	113			838	113	-	-
16	Тэба гацуур	234	31	154	22	80	9	65.8	71.0
17	Эгэл нарс	357	43	150	30	207	13	42.0	69.8
18	Түмэнсарлагтан	266	21	85	12	181	9	32.0	57.1
19	Ар санжинт	700	108	150	25	550	83	21.4	23.1
20	Баянсуудал шүтээн	1466	188	303	51	1163	137	20.7	27.1
21	Бугант номин	970	131	361	45	609	86	37.2	34.4
22	Жаврай	1289	217	537	178	752	39	41.7	82.0
23	Номголжин	1082	169	464	85	618	84	42.9	50.3
24	Нугын хишиг	1253	171	734	111	519	60	58.6	64.9
25	Түмэндалай	898	132	250	20	648	112	27.8	15.2
26	Цогт Манлай	1280	203			1280	203	-	-
27	УБТЗ-ын МБҮ	1604	207	1161	207	443	0	72.4	100.0
28	Иэн бирс	440	52	109	15	331	37	24.8	28.8

29	Ерөөлт хангай	250	14			250	14	-	-
30	Мандал оргил	750	102	370	61	380	41	49.3	59.8
31	Сансар хараа	1035	164	200	14	835	150	19.3	8.5
32	Өгөөж хараа	550	88	100	20	450	68	18.2	22.7
33	Хөвчийн ой ОН	70				70	0	-	
34	Бугант баянгол ОН	35				35	0	-	
35	Бугант баянжин ОН	90		50		40	0	55.6	
36	Эгүд ОН	110		50		60	0	45.5	
37	Бэх бөх	100				100	0	-	
38	Хайрхан хөндий ОН	140		140		0	0	100.0	
39	Баялаг ОН	150				150	0	-	
40	Гурван гол ОН	100				100	0	-	
41	Их хөвч ОН	70				70	0	-	
42	Зулзаган төгөл ОН	100				100	0	-	
43	Иргэд		2826		1059	0	1767		37.5
	Дүн	34831	7497	16525	3555	18306	3942	47.4	47.4

**Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал,
илэрсэн зөрчил дутагдал**

Ерөөгийн сум 2024 он, 2025 оны эхний хагас жилийн төсөв, санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргийг тулган шалгахад холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой нийт **89,229.1** мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт 1. 2024 онд Худалдан авалтын цахим төлбөрийн баримтын бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг, бөөн дүнгээр шивүүлсэн нийт 5,144.0 мянган төгрөгийн худалдан авалтын ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.", 13.6 дахь "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна."Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бараа ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээг журамд заасны дагуу үнэн зөв тодорхойлон шийвүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. үрийн байнгын талбай тусгаарлалтын ажлыг 5 иргэнээр гэрээгээр гүйцэтгүүлсэн хөлсийг олгохдоо хүний орлогын албан татварт 300.000.0 (Гурван зуун мянган төгрөг)-ийг суутган тайлагнаагүй.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо эдгээр орлогын нийт дүнгээр тооцно.", 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана гэж заасныг баримталж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илрүүлэлт 3. 2024 онд 6 аж ахуйн нэгж байгууллагууд нь ойн ашигласны төлбөрийн тооцоог төлөлт хийдээгүй байхад Буян од ХХК 7,791.3мянган төгрөгийг ,Бугант нандин ХХК 8,025.0 мянган төгрөгийг ,Ерөө ой мод ХХК 3,212.9 мянган төгрөгийг ,Сэлэнгэ бугант ХХК 3,212.9 мянган төгрөгийг Бугант гол ХХК 2,934.5мянган төгрөгийг нийт 27,705,199.0 (Хорин долоон сая долоон зуун таван мянган нэгэн зуун ерэн есөн төгрөг)-ийн авлагын тооцоог нийлж баталгаажуулаагүй, бүртгэл тайланд тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.",

20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх төлбөр тооцоог баталгаажуулж бүртгэл тайланд үнэн зөвөөр тусгаж, байх, албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илрүүлэлт 4. Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн Тээврийн хэрэгсэл нэр дахин ашиглах боломжгүй 56,080.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн ангилалд бүртгэлтэй ашиглах боломжгүй, 56,080.0 мянган төгрөгийн төрлийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хандаагүй

Шийдвэрлэсэн нь: Цаашид хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоож гарган тухай жилд аймгийн ОНӨГ-т хандаж байхыг зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Ерөө бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв, санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Дунд" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Ерөө бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 89,229.1 мянган төгрөгийн 4 зөрчил илэрүүлснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 33,149.1 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 56,080.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Ерөө бүсийн сумдын дундын ойн ангийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг дарга, нягтлан бодогч нарт нь хариуцуулав.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР



Д.ВАНЧИГМАА

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

ЕРӨӨ БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА



Г.ЭНХБАТ

НЯГТЛАН БОДОГЧ



Б.ӨЛЗИЙМАА